



ОРХОН АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 дугаар сарын 26

Дугаар А/18

Жаргалант сум

Ажлын хэсэг томилон  
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалт, 22.1.5 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 35.1.15 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.2.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сан болон улсын төсөв, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бараа, ажил үйлчилгээ, түүний хэрэгжилт, хадгалалт, орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, тэдгээртэй холбогдуулан гарсан журмуудын хэрэгжилтэд хяналт тавих, тооллого явуулах, дүгнэлт гаргах иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Ж.Эрдэнэ-Очир

Гишүүд: Ж.Алтантөгс

Н.Хадаа

Э.Пүрэвсүрэн

Г.Хангал

Ч.Батсуурь

О.Цэрэндулам (нарийн бичгийн дарга)

2.Ажлын хэсгийг төлөвлөгөө гарган 2025 оны 06 дугаар сарын 09-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрийн хооронд ажиллаж, тайлангаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж, санал дүгнэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсгийн дарга (Ж.Эрдэнэ-Очир)-д даалгасугай.

3.Ажлын төлөвлөгөөний дагуу шаардагдах төсвийг холбогдох зардлаас гаргахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нягтлан бодогч (Н.Мядагмаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР

6125030001